



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/423

Алтай хот

Газрын талбайн хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан Алтай хотын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө (2015-2030 он)-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөх хүсэлт ирүүлсэн Алтай орон сууцны корпораци ААТҮГ-ын эзэмшиж байгаа газрын хэмжээг өөрчлөн 1-3 дугаар хавсралтаар баталж, эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн Алтай орон сууцны корпораци ААТҮГ-ын мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.


4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/267 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20²² оны
07 сарын 06-ны өдрийн 442 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ


д/д	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Иргэн, аж ауйн нэгж байгууллагын регистрийн дугаар	Газар эзэмших ашиглах эрхийн төрөл	Нэгж талбарын түр дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт	Газар эзэмших, ашиглуулах хугацаа
1	Алтай орон сууцны корпораци ААТҮГ	3253821	Эзэмших	8208005224	2727	Оргил баг	5-8 давхар нийтийн орон сууц (2202)	13

----oOo----


"Алтай орон сууцны корпораци" ААТҮГ (3253821) - ИЙН
ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 820800 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Солонго хороолол



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)



Огноо: 2022-3-28

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэггйд
1	5138216.868	287579.940	50.45	1-2
2	5138257.868	287550.548	54.17	2-3
3	5138289.589	287594.462	50.64	3-4
4	5138248.184	287623.623	53.75	4-1

Талбайн хэмжээ: 2727.0 квадрат метр